


**Санхүүгийн тайлан ба Хараат бус  
аудиторын тайлан**

**“Ди Би Эм лизинг” ХХК**

2017 оны 12 дугаар сарын 31



# Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	3
Санхүүгийн байдлын тайлан	6
Орлогын дэлгэрэнгүй тайлан	7
Өмчийн өөрчлөлтийн тайлан	8
Мөнгөн гүйлгээний тайлан	9
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	10



## “УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ” ХХК

Хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний  
Грант Торnton Интернэйшнлийн Монгол улс дахь гишүүн

# Хараат бус аудиторын дүгнэлт

“Улаанбаатар аудит  
корпораци” ХХК  
Далай тауэр, ЮНЕСКО-гийн  
гудамж, Сүхбаатар дүүрэг-1,  
Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110744  
Ф + 976 70 110722

Ulaanbaatar audit  
corporation LLC  
Dalai Tower, UNESCO street,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230, Mongolia  
T + 976 70 110744  
F + 976 70 110722

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид “Ди Би Эм лизинг” ХХК (цаашид “компани” гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, емчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Ди Би Эм лизинг” ХХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бух материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### Үдирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг хангалттай дотоод хяналтын орчинд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцуулэн Монгол Компанийн Ерөнхийлөгч, Сайдын сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.



Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах

Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчмтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнз.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоонд үндэслэсэн дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр ач холбогдолтой өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба уг алдаа нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайлангийн үндэслэлээс шалтгаалж хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр бол материаллаг алдаанд тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болохын хувьд аудитын ажлын явцад дараах мэргэжлийн шийдэл ашиглаж, мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцаангүй эрсдэл ихтэй байдаг, учир нь залилан хийхэд хувалдах, бичиг баримт хурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоостой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зүй зохистой байдал, тооцооллын үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгад үнэлгээ өгдөг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид томоохон эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл гэнэтийн нөхцөл байдал нь Компани тасралтгүй ажиллах зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх, түүний тодруулга нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.



Бид аудитын төлөвлөгөөний хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдол зэрэгтэй холбоотой аудитаар илэрсэн томоохон асуудлуудын талаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партер нь Бөөхүүгийн Осоргарав болно.



Монгол улс, Улаанбаатар хот  
2018 оны 4 дүгээр сарын 25

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2017 оны 6 сарын 16-ны үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4	126,035	-
Санхүүгийн түрээсийн авлага	5	29,050,126	-
		29,176,161	-
Эргэлтийн хөрөнгө		-	-
Бараа материал	6	4,668	-
Худалдааны ба бусад авлага	7	10,773	-
Санхүүгийн түрээсийн авлага	5	4,508,969	-
Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж	8	4,450,169	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9	5,645,398	750,000
		14,619,977	750,000
Нийт хөрөнгө		43,796,139	750,000
<b>Өмч ба өр төлбөр</b>			
<i>Капитал ба нөөц</i>			
- Төрийн өмч	10	10,000,000	750,000
Хуримтлагдсан ашиг/(алдагдал)		87,423	-
		10,087,423	750,000
Эргэлтийн бус өр төлбөр			
Зээл	11	30,037,250	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	12	13,506	-
		30,050,757	-
Эргэлтийн өр төлбөр			
Худалдааны ба бусад өглөг	13	62,910	-
Зээл	11	3,589,390	-
Орлогын албан татварын өглөг		5,658	-
		3,657,959	-
		33,708,716	-
Нийт өмч ба өр төлбөр		43,796,139	750,000

Уг санхүүгийн тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд батлав:

О.Гэрэлмаа  
ЭМ ЛИЗИНГ  
Гүйцэтгэх захирайл

Б.Уянга  
Нягтлан бодог

Энэхүү санхүү байдлын тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 10 -аас 32 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2017 оны 12 сарын 31- нээр дуусвар болсон
Орлого	14	646,267
Борлуулалтын өртөг	15	(556,785)
Нийт ашиг		89,482
Удирдлагын зардал	16	(346,341)
Бусад зардал		(2,098)
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		348,440
Санхүүгийн орлого	17	368,314
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	18	(1,902)
Орлогын татварын өмнөх ашиг		107,455
Орлогын татварын зардал	19	(20,032)
Тайлант жилийн ашиг		87,423
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		87,423

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 10-аас 32 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Хуримтлагдаа н ашиг/ (алдагдал)	Нийт
2017.06.16-ны байдлаар	750,000		750,000
Тайлант жилийн ашиг	-	87,423	87,423
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	87,423	87,423
Гаргасан хувьцаат капитал	9,250,000	-	9,250,000
Ногдол ашиг	-	-	-
Эзэмшигчтэй хийсэн гүйлгээ	9,250,000	87,423	9,337,423
2017.12.31-ний байдлаар	10,000,000	87,423	10,087,423

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 10 -аас 32 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр

2017 оны 12  
сарын 31-нээр  
дуусвар  
болсон

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Тайлант жилийн ашиг	107,455
Тохируулгууд:	
Элэгдэл хорогдлын зардал	13,791
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	(31)
Санхүүгийн орлого	(368,314)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны алдагдал	(247,100)
Худалдааны ба бусад авлагын өөрчлөлт	(33,569,775)
Бараа материалын өөрчлөлт	(4,668)
Бусад хөрөнгийн өөрчлөлт	(4,450,263)
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн өөрчлөлт	8,506
ХХОАТ-ын өглөгийн өөрчлөлт	7,120
Худалдааны ба бусад өглөгийн өөрчлөлт	830
Бусад өр төлбөрийн өөрчлөлт	46,454
Үйл ажиллагаанаас бий болгосон /(зарцуулсан) мөнгө	(37,961,795)
Орлогын татвар төлсөн	(867)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(38,209,762)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Үндсэн ба биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(139,795)
Хүүгийн орлого хүлээж авсан	368,314
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	228,519
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Хувьцаат капитал гаргаснаас хүлээн авсан	10,000,000
Зээл өгснөөс хүлээн авсан	33,626,641
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	43,626,641
Бэлэн мөнгө ба банкин дахь үлдэгдлийн цэвэр өсөлт/(бууралт)	5,645,398
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,645,398

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 10-аас 32 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Ди Би Эм лизинг" ХХК ("Компани") нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан. Монгол улсын хуулийн дагуу Улсын бүртгэлийн албанад бүртгүүлж, 6196233 регистрийн дугаартай, 9011680088 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Үндсэн үйл ажиллагаа: Санхүүгийн түрээс буюу лизингийн үйчилгээ

Компанийн ажилтнуудын дундаж тоо 2017 оны туршид 18 байсан байна.

Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, East Plaza, 39-р байр, 5 дугаар давхар

## 2 Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

### 2.1 Үндсэн зарчим

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС") ын дагуу бэлтгэв.

### 2.2 Хэмжилтийн суурь

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэлгээгээр, зарим санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнээр, бусад тохиолдолд түүхэн өргийн суурийн аргаар бэлтгэсэн болно.

### 2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдалд хамгийн тохиромжтой учир үйл ажиллагааны валют байна.

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлэх нь тус тайланг хэрэглэх хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлагын үзсэн тул эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр мянгачилж, бүхэл тоогоор илэрхийлсэн болно.

### 2.4 Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь Удирдлагаас санхүүгийн тайлангийн өдрөөр тайлангнасан хөрөнгө, өр төлбөр, тайлант хугацааны орлого, зарлагын тайлангнасан дунд нөлөөлөх чухал таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Эдгээр тооцоолол нь тухайн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэг дээр сууриссан байдаг боловч, бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болох бөгөөд анхны тооцоолол, таамаглалыг тухайн жилийн аль тохиромжтой нөхцөл байдалтай нь уялдуулан өөрчилж болно.

### 2.5 Шинэ болон сайжруулсан стандартын хэрэглээ

Тайлант онд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ") болон СТОУС-ын Тайлбарын хороо ("СТОУСТХ")-ноос гаргасан компанийн үйл ажиллагаатай холбоотой 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хүчин төгөлдөр үйлчлэх бүх шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС")-ыг авч хэрэгжүүлсэн.

Эдгээр өөрчлөлтүүдийн шинж чанар, нөлөөллийг доор харуулна. Хэдийгээр эдгээр шинэ стандарт, өөрчлөлтүүдийг 2017 онд анх хэрэглэж байгаа боловч Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

## **2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хүчин төгөлдөр үйлчилж буй шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт түүний тайлбарууд**

Тодруулах санаачлага (НББОУС 7 *Мөнгөн гүйлгээний тайлан-д орсон өөрчлөлтүүд*)

НББОУС 7-д орсон 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөх өөрчлөлтүүд нь санхүүгийн үйл ажиллагааны өр төлбөрт гарсан өөрчлөлтийг тодруулахыг шаарддаг.

### **НББОУС 12 Орлогын албан татвар-т орсон өөрлөлтүүд**

НББОУС3 Хэрэгжээгүй гарзын хойшлогдсон татварын хүлээн зөвхөөрөлт гаргасан ба үүгээр НББОУС 12 Орлогын албан татвар-т бага хэмжээний өөрчлөлт оруулсан. Эдгээр өөрчлөлт нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн өрийн хэрэглүүртэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгийг ялангуяа зах зээлийн хүүгийн хувийн өөрчлөлт өрийн хэрэглүүрийн үнэ цэнийг өртгөөс доош багасгаж байгаа тохиолдолд хэрхэн бүртгэхийг тодорхойлоход чиглэгдсэн.

Эдгээр өөрчлөлт нь дараах асуудлуудыг тодорхойлно. Үүнд:

- Татварын зорилгоор өртгөөр хэмжигдэж, бодит үнэ цэнээр хэмжигдсэн өрийн хэрэглүүрийн хэрэгжээгүй гарз тухайн өрийн хэрэглүүрийн эзэмшигч өрийн хэрэглүүрийг худалдах эсвэл ашиглах замаар дансны үнийг нөхөх хүлээлтээс үл хамааран хасагдах түр зөрүү бий болгодог;
- хөрөнгийн дансны үнэ боломжит ирээдүйн татвар ногдуулах ашгийг хязгаарлахгүй;
- ирээдүйн татвар ногдуулах ашгийн тооцоолол хасагдах түр зөрүүний буцаалтын дүнд бий болох татварыг багтаахгүй;
- аж ахуйн нэгж татварын хууль хасагдах түр зөрүүний буцаалт дээр хасалт хийж болох татвар ногдуулах орлогын эх үүсвэрийг хязгаарладаг эсэхийг анхаарах нь зүйтэй. Хэрэв татварын хууль тийм хязгаарлалт хийдэггүй бол аж ахуйн нэгж хасагдах түр зөрүүг бусад бүх хасагдах түр зөрүүнийхээ хамтаар үнэлнэ.

Тус өөрчлөлтүүдийг өмнөх хугацаанд буцаж хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр өөрчлөлтүүд Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй байна.

## **2014-2016 оны сайжруулалтууд**

2014-2016 оны сайжруулалтаар хэд хэдэн СТОУС-д багахан өөрчлөлт оруулсан. Компанид хамааралтай өөрчлөлтүүдийг доор хураангуйлав.

### **СТОУС 12 Бусад аж ахуйн нэгж дэх хувь оролцооны тодруулга**

Стандартын хамрах хүрээний тодотгол.

СТОУС 12-ыг НББОУС 8-ын дагуу буцаж хэрэгжүүлэх шаардлагатай.

## **Компанийн хувьд хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд**

Энэхүү санхүүгийн тайлангуудыг баталгаажуулах үед Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУС3)-өөс шинээр батлан хэвлэсэн стандартууд, одоо байгаа стандартуудад оруулсан зарим нэмэлт, өөрчлөлтүүд нь тухайн Компанийн хувьд хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй байж болно.

Компаний Удирдлага нь дээрх бүх мэдэгдлүүдийг тухайн мэдэгдлийн хүчин төгөлдөр болох хугацааны дараа тайлангийн эхний үед Компаний Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгах хэрэгтэй байна. Компаний санхүүгийн тайланд хамааралтай шинээр батлан гаргасан стандартууд, одоо байгаа стандартуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг доор харуулав. Зарим шинэ стандартууд болон тайлбарууд нь Компаний санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлт байна.

### СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр (2014)

НББОУС3-өвс НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт –ийг СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр (2014) шинэ стандарттаар оруулах үйл явц дуусгавар болсон. Энэхүү шинэ стандарт нь НББОУС 39-т санхүүгийн хөрөнгийн ангилал болон хэмжилтийн талаар ихээхэн өөрчлөлт оруулж, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцох “хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдал”-ыг хүлээн зөвшөөрч, бүртгэх загварыг шинээр нэвтрүүлсэн. СТОУС 9-өөр Хейджийн нягтлан бодох бүртгэлийн хэрэглээний талаарх шинэ удирдамжийг боловсруулсан.

Энэхүү шинэ стандарт нь Компаний санхүүгийн тайланд хэрхэн нөлөө үзүүлэх талаар Компанийн удирдлага хараахан тооцоогүй байна. Шинэ стандарт 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш хүчин төгөлдөр мөрдөж эхэнэ.

### СТОУС 15 “Харилцагчтай байгуулсан гэрээний орлого”

СТОУС 15 нь НББОУС 18 “Орлого”, НББОУС 11 “Барилгын гэрээ” болон тэдгээртэй холбоотой тайлбаруудыг орлох орлого хүлээн зөвшөөрөлтийн шинэ шаардлагуудыг тусгасан. Энэхүү шинэ стандарт нь хяналтад-суурилсан орлого хүлээн зөвшөөрөлтийн загварыг бий болгож одоогийн СТОУС-д дэлгэрэнгүй тайлбарлаагүй нэмэлт зааврыг бий болгосон. Тухайлбал: олон үүрэг хариуцлагын гүйцэтгэл, хувьсах нөхцөлтэй үнэ, үйлчлүүлэгчийн буцаах эрх, нийлүүлэгчийн дахин худалдан авалтын сонголт, бусад нийтлэг асуудлуудад нэмэлт заавраар хэрхэн зохицуулалт хийхийг тодорхой тусгасан.

СТОУС 15 нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэнэ. Компанийнудирдлага СТОУС 15-ын нөлөөллийн талаар үнэлгээ хийгээгүй байна.

### СТОУС 16 Түрээс

СТОУС 16 нь түрээсийн бүртгэлд тавигдах шинэ шаардлага болон өөрчлөлтүүдийг илэрхийлнэ. СТОУС 16-аар түрээслэгчээс түрээслүүлэгчийн хөрөнгийг “ашиглах эрх” болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, түрээсийг балансад тусгахыг шаардсан.

СТОУС 16 нь мөн:

- Түрээсийн нэр томъёог өөрчилсөн;
- Түрээсийн бус зүйл, түрээсийн хувьсах төлбөр болон сонголтын хугацаа зэрэг цогц асуудлыг хөрөнгө болон өр төлбөрт бүртгэх шаардлагыг тодорхойлсон;
- Богино хугацааны түрээс болон бага үнэтэй хөрөнгийн түрээсийг чөлөөтэй болгосон;
- Зарж эсвэл эргэн түрээслэх хэлцлийн бүртгэлийг өөрчилсөн;
- НББОУС 17-ын түрээслүүлэгчийн бүртгэлд баримталсан хандлагын ихэнхийг хэвээр үлдээсэн;
- Тодруулга хийх шинэ шаардлагыг нэвтрүүлсэн.

СТОУС 16 нь 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэх тайлант үеэс хүчин төгөлдөр болно. Хэрэв СТОУС 15 Хэрэглэгчтэй байгуулсан гэрээнээс олсон орлого –ыг хэрэглэх бол энэхүү стандартыг хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн. Компанийнудирдлага нь СТОУС 16-ын Компанийнсанхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хараахан тооцоогүй байна.

### СТОУХ 22 Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа

СТОУХ 22 нь хөрөнгө, зарлага, орлогын төлбөрийг урьдчилан төлөх эсвэл хүлээн авах үеийн хөрвүүлэлтэд ашиглах ханшийн талаар авч үздэг.

**СТОУТХ 22** –ын дагуу Хөрөнгө, зардал, орлогыг анх хүлээн зөвшөөрөхөд ашиглах ханшийг тогтоох зорилгоор ажил гүйлгээ гарсан өдрийг тодорхойлох шаардлагатай. Уг ажил гүйлгээ гарсан өдөр нь урьдчилгаа гарсан эсвэл хүлээн авснаас үүдсэн мөнгөн бус хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн авсан өдөр байна.

Хэрэв хэд хэдэн төлбөр тооцооны урьдчилгаа хийсэн эсвэл хүлээж авсан бол Компанийн тухайн төлсөн эсвэл хүлээж авсан урьдчилгаа тус бүрийн гүйлгээний өдрийг тодорхойлно.

**СТОУТХ 22** нь 2018 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгднө. Урьдчилан хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.

**НББОУС 40** Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө-д орсон өөрчлөлтүүд: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх нь

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэн нэгнээс нөгөөд шилжүүлсэн нь баримтаар нотлогдсон үеийн бүртгэлийг тус нэмэлт өөрчлөлтөд тусгасан байна. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтод нийцэх эсвэл нийцэхгүй болсон үед ашиглах зориулалтын бүртгэлд өөрчлөлт бий болно. Компанийнзорилгод гарсан өөрчлөлт нь тус шилжүүлэн бүртгэх үйл ажиллагааг дэмжсэн шалтгаан болохгүй.

Өөрчлөлтүүд 2018 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгднө. Урьдчилан хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.

### **СТОУТХ 23 Орлогын албан татварын бүртгэлийн тодорхойгүй байдал**

**СТОУТХ 23** НББОУС 12-ын дагуу орлогын албан татварын бүртгэл дэх тодорхойгүй байдлын нөлөөллийг хэрхэн тусгах талаар дараах заавраар хангасан. Тухайлбал (i) тодорхойгүй татварын бүртгэлийн хандлагыг тусад нь авч үзэх эсэх, (ii) татварын албаны шалгалтын үр дүнгийн таамаглал, (iii) татвар ногдуулах ашиг (татварын алдагдал), татварын суурь, ашиглаагүй татварын алдагдал (ирээдүйд төлөх татварыг өнөөдөр орлогоор бүртгэх хандлага), ашиглаагүй татварын хөнгөлөлт (энэ нь татварын хувь хэмжээг бууруулдаг) болон татварын хувь хэмжээг тодорхойлох, мөн (iv) бодит баримт ба нөхцөл байдал дахь өөрчлөлтийн нөлөөлөл.

**СТОУТХ 23** нь 2019 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгднө. Уг хугацаанаас өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.

## **3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд**

### **3.1 Гадаад валют**

#### **Гадаад валютаарх ажил гүйлгээ**

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монголбанкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монголбанкнаас тайлагнаны өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,427.13 төгрөг, 1 евротой харьцах ханш 2,897.87 төгрөгтэй байв. (2016 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,489.53 төгрөг ба 1 евро 2,605.79) Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээрх мөнгөн бус зүйлсийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлэхээс бусад тохиолдолд түүхэн өртгөөр (ажил гүйлгээ гарсан өдрийн ханшийг ашиглан хөрвүүлнэ) нь хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдлаар тайлагнана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг эздийн өмчид, бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүү тайлант хугацааны ашиг, алдагдалд орно.

### 3.2 Үндсэн хөрөнгө

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй барилга байгууламж, тавилга эд хогшил, компьютер тоног төхөөрөмж, оффисийн тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлagnana.

Дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт үнээс хасах ба гарсан цэвэр дүнг хөрөнгийн дахин үнэлсэн дүн гарах хүртэл тооцно. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материалыг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт дахин үнэлгээ хийнэ.

Хөрөнгийн дахин үнэлгээнээс бий болсон аливаа өсөлтийг (энэ өсөлт нь өмнөх үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн ижилхэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцааж, өсөлтийг өмнө нь хассан бууралтын ашиг, алдагдал руу кредитлэж байгаагаас гадна) бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, эдийн өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдлээр толилуулна. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг ашиг алдагдлаар бүртгэнэ. Харин хөрөнгийн дахин үнэлгээнээс бий болсон дансны үнийн бууралтыг тухайн хөрөнгийн өмнөх дахин үнэлгээтэй холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн үлдэгдлээс давж байвал ашиг, алдагдлыг бууруулна.

Компани хөрөнгийг ашиглаж байх үедээ дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ. Шилжүүлсэн нэмэгдлийн дүн нь хөрөнгийн дахин үнэлгээний дүнд суурилсан элэгдэл болон хөрөнгийн түүхэн өртөгт суурилсан элэгдлийн зөрүү юм. Хөрөнгийг дахин үнэлсний дараагаар борлуулсан эсвэл ашиглалтаас хассан бол хөрөнгийн дахин үнэлгээний нөөцөд үлдсэн нэмэгдлийг шууд хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Тээврийн хэрэгсэл	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	- 3 жил
Бусад хөрөнгө	- 10 жил

### 3.3 Санхүүгийн түрээс

НББОУС 17 Түрээс-ийн дагуу түрээслэсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэл ба урамшууллыг түрээслэгч өөр дээрээ авч байвал уг хөрөнгийн эдийн засгийн эзэмшилийг түрээслэгчид шилжүүлнэ.

Дараах шалгууруудаас нэгээс илүү нөхцөлийг хангаж байвал санхүүгийн түрээс болно: Үүнд:

- Түрээсийн гэрээгээр түрээсийн хугацааны эцэст хөрөнгө эзэмших эрх нь түрээслэгчид шилжиж байвал,
- Түрээслэгч түрээсийн хугацаа дуусахад түрээслэсэн хөрөнгийг тухайн үеийн бодит үнээс харьцангуй хямд үнээр худалдан авах эрхтэй байх ба түрээслэгч түрээсийн хугацааны эцэст худалдаж авах нөхцөлийг сонгох,
- Түрээсийн хугацаа нь хөрөнгийн ашиглагдах хугацааны ихэнх хугацаа байх,
- Түрээсийн хугацааны эхэнд тогтоосон түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь түрээслэсэн хөрөнгийн бараг бүх бодит үнэ цэнэтэй тэнцүү байх

- Түрээслэсэн хөрөнгө нь тусгай шинж чанартай байх бөгөөд зөвхөн түрээслэгч түүнд томоохон өөрчлөлт хийхгүйгээр ашигладаг бол.

Хөрөнгийг санхүүгийн түрээсээр түрээслүүлж эхлэхэд уг хөрөнгийг данснаас хасч, түрээст оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын дүнтэй тэнцүү дунгээр түрээсийн авлагыг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн түрээсийг шууд санхүүжилт ба борлуулалт хэлбэрийн түрээс гэж ангилах ба борлуулалт хэлбэрийн түрээсийн үед түрээслэсэн хөрөнгийн зах зээлийн үнэ ба дансны үнэ хоорондоо тэнцүү биш байдаг бол шууд санхүүжилтийн түрээсийн үед тэнцүү байдаг.

Шууд санхүүжилтэх түрээсийн үед түрээсийн хөрөнгийн дансны үнэ болон хамгийн бага түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь тэнцүү байх учир ямар нэгэн олз, гарз тооцохгүй. Борлуулалтын хэлбэрийн түрээсийн үед түрээслүүлж буй хөрөнгийн дансны үнэ нь хамгийн бага түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс зөрүүтэй байх ба түрээсийн үйл ажиллагаа нь түрээслүүлэгчийн хувьд үндсэн үйл ажиллагаа болох эсэхээс хамааран түрээсийн орлогыг хүлээн зөвшөөрөх асуудал нь өөр өөр байна.

### 3.4 Бараа материал

Бараа материал бол бизнесийн хэвийн үйл ажиллагаанд эсвэл үйлдвэрийн процесс юм уу үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах материал болон хангамжийн хэлбэрээр худалдан борлуулах зориулалттай хөрөнгө юм. Сэлбэг, түр зогсоосон тоног төхөөрөмж, үйлчилгээний тоног төхөөрөмж зэрэг зүйлсийг үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн тодорхойлолтод нийцээгүй бол бараа материалаар хүлээн зөвшөөрнө.

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайланна. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өртөг эхэлж авснаа эхэлж зарлагадах зарчимд сууриндаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана.

### 3.5 Санхүүгийн хэрэглүүр

#### *Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт*

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний ургал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртөгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

#### *Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт*

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах байдлаар ангилна. Үүнд:

- Зээл ба авлага
- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө
- Хугацааны эцэс хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд нь санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлт өөр өөр байдаг. Санхүүгийн хэрэглүүрийн ангилал нь түүний хэмжилт, үр дүнд

бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд орлогоор хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал нөлөөтэй. Компанийн санхүүгийн хөрөнгийн хураангуйг ангиллаар нь тодруулга 3-аас харна уу.

Компани ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг тайлант хугацааны эцэс бүрт хийнэ. Бусад зардалд толилуулсан авлагын үнэ цэнийн бууралтаас бусад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгтэй холбоотой бүх орлого, зардлыг санхүүгийн зардал, санхүүгийн орлого эсвэл бусад санхүүгийн зүйлсэд толилуулна.

#### i. Зээл ба авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад худалдааны ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана.

#### Худалдааны ба бусад авлага

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртөгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Худалдааны авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийг Компани уг авлагыг анхдагч нөхцлийн дагуу бүгдийг цуглуулах боломжгүй болсон гэсэн бодит нотолгоотой болсон үед байгуулна. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг худалдааны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ. Нөөцийн дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашигт хүүний түвшингээр дискаунтчилсан ирээдүйд орохоор тооцоолсон мөнгөн гүйлгээ хоорондын зөрүү юм.

Авлагын хасагдуулгын үлдэгдлийг тайлант хугацааны ашиг, алдагдалд тусгасан төлбөр эсвэл орлогыг бүртгэж тохируулна. Харилцагчийн дансны үлдэгдэлтэй холбоотой данснаас хассан аливаа дүнг өмнө нь байсан найдваргүй авлагын хасагдуулгаас хасна. Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

#### Бэлэн мөнгө ба банкин дахь үлдэгдэл

Компанийн бэлэн мөнгөн ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

#### ii. Арилжааны буюу ашиг, алдагдалаарх бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хейджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөд суурилдаг. Энэхүү өөрчлөлтийг идэвхтэй зах зээл дэх ажил гүйлгээний шууд үр дүн, идэвхтэй зах зээл байхгүй тохиолдолд үнэлгээний аргачлалыг ашиглан тодорхойлно.

#### iii. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулахад бэлэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг, алдагдалд шилжүүлнэ. Дэлгэрэнгүй орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй, харин өмчийг тохируулна. Өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын дунд бий болсон өмнөх тайлант хугацааны хүлээн зөвшөөрсөн алдагдалыг үнэ цаасны үнийн тодорхой өсөлт бий болсон тохиолдолд ашиг алдагдалын дансанд залруулна.

#### iv. Хугацааны эцэс хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө

Хугацааны эцэс хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны Банкууд дахь хадгаламж мөн үүнд хамаарна. Компанийн удирдлага хөрөнгө оруулалтыг хугацаа дуустал эзэмших зорилготой бол түүнийг хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаар ангилна.

Хадгаламжийн үнэ цэнэ буурсан гэсэн бодитой нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийг урьдчилан тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.

#### Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан өглөг орно. Компанийн санхүүгийн өр төлбөрийн хураангуйг ангиллаар нь тодруулга 22-д харуулав.

##### i. Зээл ба зээллэг

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг тухайн зээллэгийг эзэмшигчээс авснаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Тийм тохиолдолд бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг өмчид нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

##### ii. Худалдааны ба бусад өглөг

Худалдааны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртөгөөр илэрхийлнэ.

#### 3.6 Үнэ цэнийн бууралт

##### Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиглах хугацаа нь тодорхойгүй хөрөнгийг хорогдуулахгүй бөгөөд жил бүр үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Харин хорогдуулах хөрөнгийн дансны үнэ нөхөгдөхөөргүй болсныг илтгэх өөрчлөлт, нөхцөл байдал үүссэн үед үнэ цэнийн бууралт хийх эсэхийг авч үзнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Борлуулах үнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь нөхөгдөх дүн байна. Хөрөнгийн нөхөгдөх үнэ цэнэ эсвэл мөнгө болгогч нэгж нь хөрөнгийн дансны үнээс бага байхаар тооцоологдсон бол хөрөнгийн дансны үнэ эсвэл мөнгө бий болгогч нэгжийг нөхөгдөх дүн рүү бууруулна. Холбогдох хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлж, үнэ цэнийн бууралтын гарзыг дахин үнэлгээний бууралтаар авч үзээгүй бол үнэ цэнийн бууралтын гарзыг даруй зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралт дараа үед буцаагдах тохиолдолд хөрөнгийн дансны үнэ эсвэл мөнгө бий болгогч нэгжийг хөрөнгийн дахин тооцоолсон нөхөгдөх дүн рүү өсгөн. Гэхдээ ингэснээр дансны өсгөсөн дүн нь өмнөх үед хөрөнгө болон мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг тодорхойлох байсан дансны үнээс хэтрэхгүй. Холбогдох хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлж, үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний өсөлтөөр авч үзээгүй бол үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг даруй орлогоор хүлээн зөвшөөрнө

##### Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгөд үнэ цэнийн бууралтын шинж бий эсэх үнэлгээг тайлант хугацаа бүрт хийнэ. Санхүүгийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараах нэг ба түүнээс олон үйл явдлын үр дүнд хөрөнгө оруулалтын ирээдүйд тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлсөн гэх бодит нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурна.

Хорогдуулсан өртөгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашигт хүүгээр дискаунтчилж тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүү байна. Санхүүгийн хөрөнгийн дансны үнийг хасагдуулгын дансыг ашиглан дансны үнийг бууруулсан худалдааны авлагаас бусад тохиолдолд бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзаар бууруулна.

Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрээс бусад тохиолдолд дараа үед үнэ цэнийн бууралтын алдагдал буурч, уг бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа үүссэн үйл явдалтай бодитоор холбогдох байвал өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан буцаана. Гэхдээ ингэж буцаасны улмаас үнэ цэнийн бууралтыг буцаасан өдрөөрх хөрөнгө оруулалтын дансны үнэ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөгүй байсан бол хорогдуулсан өргтийн байх дүнгээс хэтэрч болохгүй.

Борлуулах боломжтой өмчийн үнэт цаасны хувьд үнэ цэнийн бууралтын алдагдлын дараах бодит үнэ цэнийн бууралтыг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

### 3.7 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

Компанийн ойрын 12 сарын дотор борлуулахаар зорьж буй эргэлтийн бус хөрөнгө ба бүлэг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилан санхүү байдлын тайланд уг ангиллаар толилуулна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг уг ангилалд оруулахын яг өмнөх дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртөгийг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Ийм хөрөнгийг элэгдүүлж, хорогдуулахгүй. Харин санхүүгийн хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө зэрэг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хэвийн байдлаар хэмжинэ.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн борлуулалт болон дахин үнэлгээнээс гарах аливаа ашиг, алдагдлыг орлогын тайланд “бусад орлого”, “бусад зардал”-д тус тус багтаана. Хөрөнгийг данснаас хассаны үр дүнд өмчид үлдэх дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

### 3.8 Өмч

Компанийн гаргасан эздийн өмчийн хэрэглүүрийг хүлээж авсан орлогоор бүртгэнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Хуримтлагдсан ашиг, алдагдалд тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг, алдагдал багтана.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

### 3.9 Нөөц

Нөөцийг Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн эсвэл үүсмэл хариуцлага бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардлагах магадлалтай болсон үед санхүү байдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв үүний нөлөөлөл материаллаг бол нөөцийг ирээдүйд тооцоолсон мөнгөний урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн өр төлбөрийн эрсдэлд нөлөөлөх татварын өмнөх хувь хэмжээгээр дискаунтчлах замаар тодорхойлно.

### 3.10 Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр мөрдөгджэх буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай үед хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвил эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн

зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бурийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх эсэх нь тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ нь тайлант хугацааны эцэст Компани хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагас үүсэх татварын хэмжээнд нөлөөлдөг.

### 3.11 Ажилчдын тэтгэмж

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж нь тухайн ажилтанд холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж байна. Үүнд:

- (a) цалин урамшуулал;
- (b) ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- (c) нийгмийн даатгалын шимтгэл болон нийгмийн бусад төлбөрүүд

#### Урамшуулал

Компани зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд төлбөр төлөхөөс өөр бодитой хувилбарыг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр төлөхөөс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

### 3.12 Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлогыг Компаниас үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Орлого урьдчилан тооцоолсон үйлчлүүлэгчийн буцаалт, урамшуулал болон бусад төстэй хөнгөлөлтүүдээр буурна.

Орлогод орлого болон олз багтана. Орлого нь компанийн үйл ажиллагааны явцад үүсдэг бөгөөд төлбөр, хураамж, хүү болон ногдол ашиг зэргийг хамруулна. Компанийн үндсэн орлого нь хүүгийн орлого ба хураамж, шимтгэлийн орлого юм.

#### Бараа борлуулалт

Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтыг орлогоор хүлээн зөвшөөрнө:

- Компани барааны өмчлөлтэй холбоотой үүсэх мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн
- Компани борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө авч үлдээгүй
- Орлогын дунг найдвартай хэмжих боломжтой байгаа
- Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг Компани хүртэх магадлалтай
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан ба гарах зардлыг найдвартай хэмжих боломжтой байгаа.

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

### 3.13 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг Мөнгөтэй адилтгах хөрөнгөд хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилана.

## 4 Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт дүн
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ /өртөг/</b>					
2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл					
<u>Нэмэгдсэн дүн</u>	54,864	40,775	48,553	30,891	175,083
Худалдаж авсан	54,864	40,775	48,553	30,891	175,083
Капиталжуулсан	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
<u>Хасагдсан дүн(-)</u>	-	3,974	2,459	30,891	37,325
Худалдсан	-	3,974	1,520	30,891	36,385
Акталсан	-	-	-	-	-
Шилжүүлсэн	-	-	940	-	940
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	54,864	36,801	46,094	-	137,759
<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b>					
2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	-	-	-	-	-
<u>Нэмэгдсэн дүн</u>	3,440	1,981	6,867	1,503	13,791
Байгуулсан элэгдэл	3,440	1,981	6,867	1,503	13,791
Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	-	-	-
<u>Хасагдсан дүн</u>	-	209	356	1,503	2,067
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	-	-	-	-	-
Борлуулсан хөрөнгийн элэгдэл	-	209	356	1,503	2,067
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,440	1,772	6,512	-	11,724
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН</b>					
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	51,423	35,030	39,582	-	126,035

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14 тоот шийдвэрээр үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 64,215.7 мянган төгрөгийн хөрөнгийг "Ди Би Эм ассет менежмент" ХХК-д шилжүүлсэн байна.

Элэгдлийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Тодруулга 16-гийн элэгдэл хорогдлын зардал" -д тусгасан.

## 5 Санхүүгийн түрээсийн авлага

Компани нь тодорхой түрээслэсэн хөрөнгөд санхүүгийн түрээсийн зохицуулалт хийдэг. Бүх түрээсийг төгрөгөөр (шаардлагатай бол бусад валют) илэрхийлдэг. Санхүүгийн түрээсийн хугацаа нь 2.6-10 жил байна.

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
Нэг жилийн дотор	
Хүүгийн авлага	600,726
Алданги авлага	166
Үйлчилгээний шимтгэл	(15,493)
Тооцоо	(4,854)
Түрээсийн авлага	3,928,424
	<u>4,508,969</u>
1 жилээс дээш	
Түрээсийн авлага	29,109,403
Үйлчилгээний шимтгэл	(59,277)
	<u>29,050,126</u>
Нийт түрээсийн авлага	<u>33,559,095</u>

Санхүүгийн түрээсийн хамгийн бага түрээсийн төлбөр нь дараах байдалтай байна.

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
Нэг жилийн дотор	
Түрээсийн төлбөрийн авлага	3,928,424
Хүүгийн төлбөрийн авлага	<u>2,017,101</u>
	<u>5,945,525</u>
2-5 жилд	
Түрээсийн төлбөрийн авлага	27,383,302
Хүүгийн төлбөрийн авлага	<u>3,680,127</u>
	<u>31,063,429</u>
5-аас дээш жилд	
Түрээсийн төлбөрийн авлага	1,726,101
Хүүгийн төлбөрийн авлага	<u>204,683</u>
	<u>1,930,784</u>
Цэвэр өнөөгийн үнэ цэнэ	<u>38,939,738</u>

2017 оны 07 дугаар сарын 28-ны өдөр "Тариалан Эрхлэлтийг Дэмжих Сан"-тай байгуулсан санхүүгийн гэрээгээр 9.9 сая ам.долларын үнэ бүхий тоног төхөөрөмжийг жилийн 5.6 хувийн хүүтэй 5-н жилийн хугацаатайгаар түрээслүүлсэн.

"Баруун Баян Транс" ХХК-ийн Монгол улсын Хөгжлийн банкнаас тоног төхөөрөмж худалдан авах зорилготойгоор зээлсэн 454 сая иенийн зээлийг компанийн нэр дээр жилийн 7.5 хувийн хүүтэй, 2020 оны 05 сарын 29 хүртэл төлөх нөхцөлтэйгээр шилжүүлэн авсан.

Зам тээврийн салбарын "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тесэл" -ийг хэрэгжүүлэх Засгийн газрын 197 тогтоолын хүрээнд Сангийн яам, Зам тээврийн яамтай

байгуулсан гэрээний дагуу нэгж өртөг нь 270 сая төгрөгийн үнэтэй нийт 12 ширхэг автобусыг б аж ахуйн нэгжид санхүүгийн түрээсээр жилийн 4.5 хувийн хүйтэй, 10 жилийн хугацаатай олгоод байна.

Санхүүгийн түрээсийн авлагын эргэн төлөлтийг тооцохдоо Компани нь санхүүгийн түрээс олгосон өдрөөс тайлант өдөр хүртэлх эргэн төлөлтийн өөрчлөлтийг авч үздэг. Санхүүгийн түрээсийн эрдэлийн төвлөрлийг томоохон харилцагчийн хүрээнд авч үздэг ба найдвартгүй авлагын нөөцийн сангт байгуулаагүй байна.

Валютаар илэрхийлсэн санхүүгийн түрээсийн авлагыг Тодруулга 22-аас харна уу.

## 6 Бараа материал

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
Бичиг хэргийн материал	1,205
Хангамжийн материал	3,463
	<u>4,668</u>

## 7 Худалдааны ба бусад авлага

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
Худалдааны авлага	-
Худалдааны бусад авлага	1,266
	<u>1,266</u>
Найдвартгүй худалдааны авлагын хасагдуулга	-
Цэвэр худалдааны авлага	1,266
	<u>1,266</u>
Урьдчилгаа, урьдчилж төлсөн тооцоо	8,884
Бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага	381
Ажилчдаас авах авлага	242
	<u>9,507</u>
	<u>10,773</u>

Худалдааны авлагын цэвэр дансны үнэ нь бодит үнэтэй ойролцоо гэж үзсэн ба бүгд богино хугацаатай байна. Худалдааны авлагад хүү тооцохгүй.

Эдгээр авлагын насжилтын шинжилгээг дор харуулав:

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
6 сараас бага	1,266
6 сараас 1 жил	-
1 жилээс дээш	-
	<u>1,266</u>

## 8 Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж

Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь дараах байдалтай байна. Үүнд:

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</i>
Банкин дахь хадгаламж (Төгрөг)	3,841,935
Банкин дахь хадгаламж (Ам.доллар)	608,234
	<u><u>4,450,169</u></u>

## 9 Мөнгө, харилцахын үлдэгдэл

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</i>
Бэлэн мөнгө	91
Банкин дахь харилцах, хадгаламж *	<u><u>5,645,307</u></u>
	<u><u>5,645,398</u></u>

\*Банкинд байршуулсан хөрөнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь дараах байдалтай байна. Үүнд:

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</i>
Банкин дахь харилцах (Төгрөг)	268,770
Банкин дахь харилцах (Ам.доллар)	6,247
Банкин дахь харилцах (Рубль)	9
	<u><u>275,026</u></u>
Банкин дахь хадгаламж (Төгрөг)	5,370,281
Банкин дахь хадгаламж (Ам.доллар)	-
	<u><u>5,370,281</u></u>
	<u><u>5,645,307</u></u>

## 10 Капитал ба нөөц

### 10.1 Хувьцаат капитал /Төрийн өмч/

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>Хувьцааны тоо</i>	<i>Нэг бүрийн үнэ</i>	<i>Нийт дүн</i>
Ахь үүсгэн байгуулах үед гаргасан хувьцаа	15,000	50,000	750,000
Тайлант жилд нэмж гаргасан болон бүрэн төлсөн	185,000	50,000	9,250,000
	<u><u>200,000</u></u>	<u><u>50,000</u></u>	<u><u>10,000,000</u></u>

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр нэг бүр нь 50,000 төгрөгийн үнэтэй 185,000 ширхэг, нийт 9,250,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцааг нэмж гаргасан байна.

## 10.2 Хяналт

Компанийн бүх энгийн хувьцааг Монгол Улсын Хөгжлийн банк эзэмшиж, 100% хянадаг. Компанийн дээд толгой байгууллага болох Монгол Улсын Хөгжлийн банк нь Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан бөгөөд Засгийн газрын шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг.

## 11 Зээл ба зээллэг

Мянган төгрөгөөр	Bогино хугацаат зээл	Урт хугацаат зээл
	2017.12.31	2017.12.31
<b>Банкны зээл</b>		
СЯ-наас авсан зээллэг*	-	3,240,000
Хүүгийн өглөг	1,549	-
<b>Холбоотой талаас авсан зээллэг</b>		
МУХБ-ам.доллар**	-	21,465,640
Хүүгийн өглөг	457,890	-
МУХБ-иен***	3,080,318	5,331,611
Хүүгийн өглөг	49,633	-
	<b>3,589,390</b>	<b>30,037,250</b>

\* “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан 116 тоот “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний дагуу нийтийн тээврийн компаниудад автобусыг санхүүгийн түрээсээр олгох зорилгоор 11,610 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулсан ба тайлант хугацаанд нийт 3,240 сая төгрөгийг зээлийг 12 жилийн хугацаатай, жилийн 2.25%-ийн хүйтэй авсан байна.

\*\* Компани нь “Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, улаан буудайн үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд ОХУ-аас худалдан авах хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх зорилгоор ОХУ-ын төрийн өмчтэй “Хөгжил болон гадаад эдийн засгийн асуудал эрхэлсэн банк” (Внешэкономбанк)-ний эх үүсвэрээс Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан 10 сая ам.долларын зээлийг 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 5 жилийн хугацаатай, 3.6 хувийн тогтмол хүйтэйгээр авсан байна.

\*\*\* “Баруун Баян Транс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих” төслийн хүрээнд санхүүгийн түрээс олгох зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас 454 сая иенийн зээлийг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 2.6 жилийн хугацаатай, жилийн 5.95% хүйтэйгээр авсан байна.

Урт хугацаат зээлийн бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

	Bодит үнэ цэнэ	Дансны үнэ
	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр		
Сангийн яамнаас авсан зээллэг	3,240,000	3,240,000
Холбоотой талуудаас авсан зээллэг	29,863,006	29,863,006
	<b>33,103,006</b>	<b>33,103,006</b>

Богино хугацаат зээл ба зээллэгийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ тэнцүү гэж үзсэн.  
Валютаарх зээлийн талаар Тодруулга 22-с харна уу.

## 12 Хойшлогдсон орлогын албан татвар

Хойшлогдсон орлогын албан татварын хөдөлгөөнийг доор тодруулав:

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	-
Эхний үлдэгдэл	-
Ашгийг бууруулсан (Тодруулга 18-аас харна уу)	13,506
Эцсийн үлдэгдэл	13,506
	<u><u>13,506</u></u>

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хугацааны хойшлогдсон орлогын албан татвар нь дараах байдалтай байна:

	Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн	Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн	2017 оны 12 дугаар сарын 31
Хойшлогдсон татварын өр төлбөр			
Хүүгийн орлоготой холбоотой цаг хугацааны зөрүүнээс үүссэн	-	13,506	13,506
Цэвэр дүн-хойшлогдсон татварын өр төлбөр	-	13,506	13,506
	<u><u>-</u></u>	<u><u>13,506</u></u>	<u><u>13,506</u></u>

## 13 Худалдааны ба бусад өглөг

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Мянган төгрөгөөр	-
Урьдчилж орсон орлого	17,840
Ажилчдад өгөх өглөг	830
НДШ-ийн өглөг	8,506
ХХОАТ -ийн өглөг	7,120
Харилцагчид өгөх өглөг	1,589
Холбоотой талд өгөх өглөг	27,025
	<u><u>62,910</u></u>

## 14 Орлого

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	-
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого- Тариалан эрхлэлтийг дэмжих сан	545,100
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого - Баруун баян транс ХХК	98,202
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого - Нийтийн тээврийн компаниуд	2,965
	<u><u>646,267</u></u>

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг тул санхүүгийн түрээсийн хүүгийн орлогыг үндсэн орлого гэж үзсэн.

## 15 Борлуулалтын өртөг

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	
Хүүгийн зардал - МУХБ /ам.доллар/	483,341
Хүүгийн зардал - МУХБ /иен/	71,895
Хүүгийн зардал - Сангийн яам	1,549
	<u>556,785</u>

## 16 Ерөнхий удирдлагын зардал

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	
Ажиллагчдын цалингийн зардал	199,978
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	21,957
Томилолтын зардал	35,803
Бичиг хэргийн зардал	5,214
Шуудан холбооны зардал	4,134
Мэргэжлийн үйлчилгээний зардал	9,914
Даатгалын зардал	196
Ашиглалтын зардал	2,897
Засварын зардал	1,191
Элэгдэл, хорогдлын зардал	13,791
Түрээсийн зардал	45,949
Шатахууны зардал	5,317
	<u>346,341</u>

## 17 Санхүүгийн орлого, зардал

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	
Хадгаламжийн хүүгийн орлого	144,117
Банкны үлдэгдэл тооцсон хүүгийн орлого	56,201
Засгийн газрын бондын хүүгийн орлого	167,997
Нийт санхүүгийн орлого	<u>368,314</u>

## 18 Орлогын татварын зардал

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	
Тайлант жилийн ААНОАТ-ын татвар	6,525
Хойшлогдсон татварын зардал (тодруулга 12-с харна уу)	13,506
	<u>20,032</u>

Үр ашигт татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	Үр ашигт татварын хувь хэмжээ (%)
Мянган төгрөгөөр		
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	107,455	
Тусгайлсан татварын хувь хэмжээгээр тооцох орлого	(65,255)	
Чөлөөлөгдхө орлого	(167,997)	
Татвар ноогдох орлогоос хасагдахгүй зардал	2,703	
Хойшлогдсон татвараар хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүүний нөлөөлөл	49,264	
Хойшлогдсон татвараар хүлээн зөвшөөрсөн түр зөрүүний нөлөөлөл	(135,063)	
Нийт татвар ногдох орлого	<u>(208,893)</u>	
Нийтлэг татварын хувь хэмжээгээр тооцсон татвар 10%	-	0.00%
Тусгайлсан татварын хувь хэмжээгээр тооцсон татвар 10%	6,525	1.63%
Хойшлогдсон татварын зардал	13,506	3.37%
Орлогын татварын зардал	<u>20,032</u>	<u>5.00%</u>

## 19 Балансын дараах үйл явдал

Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тайлагналын өдрөөс хойш аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд уг санхүүгийн тайланд нөлөөлөхүйц материаллаг дүн бүхий ажил гүйлгээ гараагүй, нөлөө бүхий шийдвэр гараагүй, томоохон үйл явдал тохиолдоогүй байна.

## 20 Нягтлан бodoх бүртгэлийн тооцоолол ба үнэлэмж

Тооцоолол болон үнэлэмжийг ирээдүйн үйл явдлын таамаглал, түүхэн туршлага, бусад хүчин зүйлсэд үндэслэн байнга хийдэг бөгөөд тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзнэ.

### 20.1 Нягтлан бodoх бүртгэлийн тооцоолол

Компани нь ирээдүйн талаарх тооцоолол, таамаглалыг хийдэг. Нягтлан бodoх бүртгэлийн тооцооллын үр дүн нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилд хөрөнгө ба ер төлбөрийн дансны үнэд материаллаг хэмжээний залруулга хийхээс шалтгаалан томоохон эрсдэл үүсэж болох тооцоолол, таамаглалыг доор харуулав.

## Үндсэн хөрөнгийн ашиглагдах жил

Удирдлага нь үндсэн хөрөнгөд ашиглагдах жилийг тооцсон байна. Удирдлагын зүгээс үндсэн хөрөнгийн тооцсон ашиглагдах жил нь эдгээр хөрөнгийн эдийн засгийн ашиглагдах жилээс материаллаг хэмжээний зөрүүгүй гэж үзэж байна. Хэрэв үндсэн хөрөнгийн бодит ашиглагдах жил нь тооцооллоос зөрүүтэй бол санхүүгийн тайлан нь материаллаг зөрүүтэй болно.

### Санхүүгийн түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэнэ

Компанийн санхүүгийн түрээсийн хэлбэр нь шууд санхүүжүүлэх түрээс учир түрээсийн хөрөнгийн дансны үнэ болон хамгийн бага түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь тэнцүү гэж компанийн удирдлага үзсэн учир түрээсийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн олз, гарз тооцогүй.

## 21 Санхүүгийн хэрэглүүр

### 21.1 Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулга 3-д дэлгэрэнгүй харуулсан болно.

### 21.2 Санхүүгийн хэрэгслийн ангилал

Санхүүгийн байдлын тайландаа тайлагнасан дансны үнэ нь дараах хөрөнгө, өр төлбөрийн ангилалтай холбоотой:

#### Санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Зээл ба авлага:	
Худалдааны болон бусад авлага	10,773
Санхүүгийн түрээсийн авлага	33,559,096
Банкинд байршуулсан хадгаламж	4,450,169
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	5,645,398
	43,665,436

#### Санхүүгийн өр төлбөр

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Зээл, зээллэг	
Худалдааны болон бусад өглөг	33,626,641
	62,910
	33,689,551

## 22 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрөвөх чадварын эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгө болон опцион худалдаалаагүй байна.

Компанид тулгарч буй томоохон санхүүгийн эрсдэлүүдийг дор харуулав.

## Санхүүгийн эрсдэлийн хүчин зүйлс

### a) Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.

#### Гадаад валютын эрсдэл

Компани нь санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор гадаад валютаар зээл авч, харилцагчиддаа санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг. Иймээс гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлд өртдөг байна.

Валютын эрсдэлд өртж буй гадаад валютаар хийгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дор харуулав. Доорх дүнг Монгол банкны 2017 оны 12 сарын 31-ний хаалтын ханшаар Монгол төгрөг рүү хөрвүүлж, тайлагнасан байна. Үүнд:

#### Ангилал

	Ам.доллар	Иен	Рубль
2017 оны 12 дугаар сарын 31-ээрх			
<b>Санхүүгийн хөрөнгө</b>			
Худалдааны болон бусад авлага	-	-	-
Санхүүгийн түрээсийн авлага	21,386,950	9,073,418	-
Бусад банкинд байршуулсан хадгаламж	608,234	-	9
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	6,247	-	-
	<u>21,995,184</u>	<u>9,073,418</u>	<u>9</u>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Зээл, зээллэг	21,923,530	8,461,562	-
Худалдааны болон бусад өглөг	-	17,840	-
	<u>21,923,530</u>	<u>8,479,402</u>	<u>-</u>
Цэвэр дүн	<u>71,654</u>	<u>594,016</u>	<u>9</u>

Ам.доллар болон иенийн эсрэг төгрөгийн 10%-ийн өсөлт ба бууралтад үзүүлэх Компанийн мэдрэмжийг доорх хүснэгтээр харуулав. 10% нь гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтөд өгөх удирдлагын үнэлгээг харуулдаг. Мэдрэмжийн шинжилгээнд зөвхөн одоогийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад валютын ханшийн 10% -ийн өөрчлөлт дэх тайлант хугацааны эцэст хийсэн нь хөрвүүлэлтийн тохируулга багтана.

Хэрэв төгрөг нь ам.доллар болон иенийн эсрэг 10% -аар чангарвал, дараах нөлөөг үзүүлэх болно:

Мянган төгрөгөөр	Ам.долларын нөлөө		Иенийн нөлөө	
	2017	2016	2017	2016
Ашиг (алдагдал)	7,165	-	59,402	1
	<u>7,165</u>	<u>-</u>	<u>59,402</u>	<u>1</u>

Хэрэв төгрөг ам.доллар болон иенийн эсрэг 10% -аар супарвал ам.доллароос 7,165 төгрөг, иенээс 59,402 мянган төгрөгийн алдагдал хүлээхээр байна.

### b) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн борлогдох хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Дараах хүснэгтээр гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаатай үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдийг төлөх Компанийн үлдсэн гэрээний хугацааг харуулав. Компани төлөх шаардлагатай эхний өдөр санхүүгийн өр төлбөрийн дискаунтчилгаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэн уг хүснэгтийг гаргасан. Хүснэгтэд хүү болон үндсэн мөнгөн гүйлгээг харуулсан.

Мянган төгрөгөөр	3 сар хүртэлх хугацаатай	3 - 6 сарын хугацаатай	6 -12 сарын хугацаатай	1 жилэс дээш хугацаатай	Нийт дүн
<b>ТАЙЛАНТ ОН:</b>					
Нийт санхүүгийн хөрөнгө	5,645,398	8,969,911	-	29,050,126	43,665,436
Нийт санхүүгийн өр төлбөр	986,494	1,777,204	888,602	30,037,250	33,689,551
<b>Санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадварын зөрүү</b>	<b>4,658,904</b>	<b>7,192,707</b>	<b>(888,602)</b>	<b>(987,126)</b>	<b>9,975,884</b>

Компани нь хөрвөх чадварын эрсдэл ялангуяа мөнгөний эх үүсвэр, худалдааны авлагыг үнэлэх, удирдахад санхүүгийн хөрөнгийн хулээгдэж буй мөнгөн урсгалыг авч үздэг. Компанийн мөнгөн хөрөнгө болон санхүүгийн түрээсийн авлага, худалдааны ба бусад авлагаас орж ирэх мөнгөн урсгал нь ирээдүйд төлөх мөнгөн урсалаас их байна.

## 23 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь бодит үнэ цэнийг ажиглан зэргээр нь 1-3 түвшинд хуваан бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд ашигладаг санхүүгийн хэрэгслийн шинжилгээг хийдэг. Эдгээр түвшин нь:

- Түвшин 1: - Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ажиглан тодорхойлно;
- Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ажиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;
- Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөл тулгуурлахгүйгээр (ажиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно.

Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахаад бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг ба компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг бодит үнэ цэнийн ангиллын Түвшин 1-д ангилсан. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзсэн тул ямар нэгэн тохируулга хийгдээгүй.

Мянган төгрөгөөр	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
2017 оны 12-р сарын 31-ний байдлаар			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,095,567	-	-
Худалдааны болон бусад авлага	33,569,868	-	-
Худалдааны болон бусад өглөг	33,695,210	-	-

Компани нь байгуулагдаад удаагүй ба компанийн эзэмшилд байгаа санхүүгийн бус хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангиллын Түвшин 3-д ангилсан. Эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнийг тусгай зөвшөөрөл эзэмшдэг хөндлөнгийн мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний хийсэн

үнэлгээнд үндэслэн тооцох шаардлагатай боловч компани нь байгуулагдаад удаагүй ба компанийн хэрэгцээнд худалдан авсан хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээрээ ойролцоо учир дахин үнэлгээ хийлгэх шаардлагагүй гэж үзсэн.

## 24 Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөе удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, дахин үнэлгээний тохируулгын нөөц, хурийтлагдсан ашиг, эздийн өмчийн бусад хэсгээс бүрдэнэ.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

	2017 оны 12 сарын 31-ний Үлдэгдэл
Мянган төгрөгөөр	
Нийт эздийн өмч	10,087,423
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	<u>5,645,398</u>
Капитал	<u>4,442,025</u>
Нийт эздийн өмч	<u>10,087,423</u>
Зээл ба зээллэг	<u>33,626,641</u>
Бүх санхүүжилт	<u>43,714,064</u>
Нийт санхүүжилт дэх капиталын харьцаа	10.16%

## 25 Холбоотой тал

Компанийн холбоотой талуудад толгой компани болон хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно. Компани нь Монгол улсын Хөгжлийн банкны 100%-ийн хөрөнгө оруулалттай байгуулагдсан бөгөөд ямар нэгэн охин, хараат болон хамтарсан компани эзэмшдэггүй.

### 25.1 Холбоотой талтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд Компани нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн бөгөөд тайлант хугацааны эцсээр дараах үлдэгдэлтэй байна.

	2017 оны 12 сарын 31- нээр дуусвар болсон
Мянган төгрөгөөр	
Үлдэгдэл	
Толгой компаниас хүлээн авсан зээл	30,385,092
Худалдааны ба бусад өглөг	
	30,385,092

### 25.2 Удирдлага болон тэдний ойр дотны гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Ажилтнуудын цалингийн тооцооноос харахад Компанийн удирдлага нь тайлант жилд дараах цалинг авсан байна. Компанийн удирдлагад Гүйцэтгэх захирал болон дэд захирлыг хамааруулан ойлгоно.

Мянган төгрөгөөр

2017 оны 12  
сарын 31-  
нээр дуусвар  
болсон

Цалин урамшуулал

54,571

Бусад

-

54,571

## 26 Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.